



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 647

Улаанбаатар хот

“Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2019 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Т.Бямбадоржид даалгасугай.


4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002763




Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
6447 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТАЛЫН ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2019 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	х.нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 оны		2019 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл		2019 төл/ 2018 ХБГ	2019 ХБГ- 2018 төл
1	Нийт орлого	мян.төг	395,885.2	493,939.5	502,159.1	596,092.9	118.7	(93,933.8)
Үүнээс	Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	мян.төг	290,267.2	336,363.6	331,272.7	290,590.9	87.7	40,681.8
	Орон нутгийн чанартай замын ажил	мян.төг	105,618.0	157,575.9	170,886.4	305,502.0	178.8	(134,615.6)
2	Нийт зардал	мян.төг	382,860.7	484,060.7	491,425.1	584,171.0	121.3	(104,667.8)
3	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	86,306.7	103,337.3	99,442.7	122,324.7	587.4	(484,728.3)
	Татаарын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	13,024.5	9,878.8	10,734.0	11,921.9	1,139.6	(111,590.7)
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	11,722.1	8,890.9	9,660.6	10,729.7	123.4	(2,261.3)
5	Төсөвт төлөх татвар	мян.төг	78,216.7	115,724.7	96,131.6	139,038.0	144.6	(42,906.4)
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	1,778.2	1,172.2	966.1	82.4	206.2
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	24	30	24	30	125.0	(6.0)
8	Нийт цалингийн сан	мян.төг	126,916.5	204,540.0	126,916.5	220,800.0	174.0	(93,883.5)
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	440.7	568.2	440.7	583.8	132.5	(143.1)
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.97	0.98	0.98	0.98	100.1	(0.0)
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	6,235.8	136,500.0	117,800.0	99,800.0	84.7	18,000.0
12	Нийт авлага	мян.төг	48,185.6	20,000.0	18,500.0	35,000.0	189.2	(16,500.0)
13	Үүнээс: Найдваргүй	мян.төг	-	-	-	-	-	-
	Нийт Өглөг	мян.төг	25,071.4	26,445.4	26,445.4	26,445.4	100.0	-
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	3,626.0	5,000.0	5,000.0	5,000.0	100.0	-
	Урт хугацаат өр төлбөр /кувейтын сангийн өгнөг/	мян.төг	21,445.4	21,445.4	21,445.4	21,445.4	100.0	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн
647 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"ТАЛЫН ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)
1	Шуурхай ажлын хэсгийн байрны гарааш	ширхэг	1	37,000.0	37,000.0
2	Өөрөө буулгагч /хово/	ширхэг	1	49,800.0	49,800.0
3	Конторын засвар	ширхэг	1	13,000.0	13,000.0
	Нийт үнэ				99,800.0